



БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ 02 САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Боловсролын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, салбарын хүрээнд мөрдөх, хууль, засгийн газрын бодлого, яамны хүрээний үндэсний хөтөлбөр, журмыг шинжлэн мандатын шинжилгээ хийсэн. Сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудын хүрээнд, бодлогын зорилт бүрээр SWOT шинжилгээ хийж, стратегийн зорилтыг тодорхойлох ажлыг зохион байгуулсан. БСУГ-ын 2021 оны байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулах ажил хийгдэж байна.

Боловсролын салбарын удирдах ажилтнууд, БХИ-ээс зохион байгуулсан “Чадварлаг багш” арга хэмжээг танилцуулах сургалт, ЗГ, Удирдлагын академээс зохион байгуулсан “Төрийн албаны ёс зүй” сургалтанд тус бүр хамрагдаж, нийт 30 удирдах ажилтан, мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.

Сургуулийн өмнөх боловсрол:

Сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэргэжлийн бүлгийг арга зүйч нараар ахлуулан, сургалтын агуулгын хоцрогдлыг арилгах ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд төрийн 6 цэцэрлэгийн 45 багш нарыг хамруулсан. Цахим хэлэлцүүлэг 5 удаа, арга зүйч нарын мэргэжил арга зүйн хэлэлцүүлэгийг 2 удаа хийсэн. Багш нар хоцрогдсон агуулгыг нөхөх 35 цахим хичээлийг шинээр бэлтгэн хүүхдүүдэд хүргэн ажиллаж байна.



Багш нартай цахим хичээлийн зохион байгуулахад тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам тэдний сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

“Багш нар хүүхэдтэй эерэг аргаар харилцах арга зүй” сэдэвт сургалтанд БСУГ-ын мэргэжилтэн, цэцэрлэгийн арга зүйч нар хамрагдсан. Сургалтаар хүмүүжлийн эерэг аргаар хүүхдийг хэрхэн хүмүүжүүлэх, ардын уламжлалт аргаас суралцсан.



Ерөнхий боловсролын чиглэлээр:

БШУ-ны яам, Боловсролын хүрээлэнгээс мэргэжлийн багаар ажиллах ажлын чиглэл, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Мэргэжлийн багийн ахлагч нар, мэргэжлийн багш нарын хүрээнд, 21 онлайн хурлыг зохион байгуулж, дадлага-1,2,3 хүрээнд хамтран ажиллах, ажлын чиглэлээ тодорхойлсон.

Мэргэжлийн багийн ахлагч нар, дадлага-1,2 -ын хүрээнд багш нарт тулгамдсан асуудал, 1-р улирлын сургалтын хөтөлбөрөөс орхигдсон агуулгыг тодорхойлж, БХ-нд, мэргэжлийн багийн ахлагч нарт илгээгээд байна. Ажлын чиглэлийн дагуу, мэргэжлийн багш нар “дадлага-3” ын хүрээнд, 2-р улирлын сургалтын хөтөлбөрийн тохируулга хийж, дахин төлөвлөх ажлыг, зохион байгууллаа. Мэргэжлийн багийн ахлагч нар сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг БХ-нд илгээгээд байна.



Бага боловсролын мэргэжлийн багийн хүрээнд 1-5 дугаар ангийн 6 хичээлийн жилийн төлөвлөлтийг шинэчлэн боловсрууллаа. 2 дугаар ангийн Монголхэлний “Төсөөлж таамаглаж уншъя” нэгж хичээлийн жишиг хөтөлбөр, 4 дүгээр ангийн Байгалийн ухааны хичээлээр “Соронзны гайхамшиг” сэдвээр нэгж хичээлийн жишиг хөтөлбөр, Иргэний ёс зүйн боловсрол хичээлээр 4 дүгээр ангид, “Таван хошуу малын ашиг шим”, 5 дугаар ангид, “Зочлох ёс” нэгж хичээлийн

жишиг хөтөлбөрийг сайжруулан боловсруулсан. Үндэсний хэмжээнд Боржигон соёл, орон нутгийн онцлогтой хөтөлбөр хэрэгжүүлдэг, туршлагаа түгээн дэлгэрүүлсэн.

Англи хэлний хичээлээр, ЭНШ-д суралцагчдаа амжилттай бэлтгэх, арга зүйгээ сайжруулах зорилгоор, МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн багш, доктор, дэд профессор Б.Тунгалаг багшийг урин, Англи хэлний багш нарт 9 цагийн онлайн сургалтыг зохион явууллаа. Сургалтанд нийт 22 багш хамрагдаж, мэдлэг боловсролоо дээшлүүлээ.



БХИ-ийн 1,5 дахь жилийн үндсэн сургалтанд 47 багшийн бүртгэлийг баталгаажуулсан. 5 дахь жилийн үндсэн сургалтанд, удирдах ажилтан 1, цэцэрлэгийн багш-2, сургуулийн -11 багш, хичээл сонголтонд хамрагдаж байна.

ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагчдыг ЭНШ -д бүртгүүлэх, сурагчдын судалгааг нэгтгэсэн. ЭНШ-ын “Сорилго-1” онлайн шалгалтын удирдамж боловсруулж, сургуулиудад хүргэсэн. Үнэлгээний шинжээч нартай хамтран, 12 дугаар ангийн 9 хичээлээр, блюпринт боловсруулж, 344 даалгавраар, Google form ашиглан, онлайнаар зохион байгуулж байна.

№	Хичээлийн нэр	II/24	II/25
1	Хими	10:00-11:40	
2	Физик	12:00-13:40	
3	Монгол хэл	14:00-15:20	
4	Англи хэл	16:00-17:20	
5	Биологи	18:00-19:20	
6	Математик		10:00-11:40
7	Нийгэм		12:00-13:20
8	Орос хэл		14:00-15:20
9	Түүх		16:00-17:20
10	Газарзүй		18:00-19:20

ЭНШ-ийн сорилго 1 шалгалтанд хамрагдах сурагчдын тоон мэдээлэл

Хичээлийн нэр	I-сургууль	II-сургууль	III-сургууль	V-сургууль	Нийлбэр
1 Хими	11	2	7	16	36
2 Физик	24	16	9	14	63
3 Монгол хэл	33	31	9	26	99
4 Англи хэл	35	32	18	52	137
5 Биологи	11	2	7	15	35
6 Математик	47	39	20	44	150
7 Нийгэм	33	40	20	45	138
8 Орос хэл	0	0	0	0	0
9 Түүх	3	1	0	1	5
10 Газарзүй	0	2	0	2	4
	197	165	90	215	667


Соёл урлагийн чиглэлээр:

1. Соёл, урлагийн салбарын 2020 оны үйл ажиллагааны тайлан мэдээг ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт 02 сарын 10-ны өдөр хүргүүлсэн. Салбарын мэдээ тайланг инфогарфикаар мэдээлэл бэлтгэн 3 удаа сурталчилж цахим хуудсанд байршуулан 1859 хүн үзэж мэдээлэл авсан байна.
2. Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд зөвлөмж өгөх
3. СУБ-ын ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх цахим сургалтыг 3 удаа явуулсан. Google meet программыг ашиглан Боржигин өв музейн ажилтнуудад цахим сургалт явуулсан. “Төрөөс баримтлаж буй соёлын бодлого”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм” 2 цахим хичээл бэлтгэн цахим хуудсанд байршуулсан.
4. "Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт" Удирдлагын академийн богино хугацааны зайн сургалтанд 02 сарын 01-19-ний хугацаанд хамрагдсан.
5. 02-р сарын 01-ний өдрөөс 02-р сарын 07-ний өдрийг хүртэл Цагаан сарын баярын өдөрт зориулсан “Хи Хи Хи” ардын дууны зохиомжит концертийн дүрс бичлэгийг хийсэн. Уран бүтээлчдийг анги ангиар нь цагийн зохицуулалттай цуглуулан бичлэг хийсэн.
6. 02-р сарын 12-ний өдөр “Хи Хи Хи” ардын дууны зохиомжит концертийг Дуу бүжгийн Боржигин чуулгын фейж хаягаар үзэгч түмэндээ хүргэсэн. Нийт



22637 хүнд хүрч, 3108 хүн үзсэн байна.

7. Цар тахлаас сэргийлэх аймгийн онцгой комиссын мэдээлэл сурталчилгааны алба иргэдийг халдварт өвчнөөс сэргийлэх 45 удаагийн зөвлөмж, цаг үеийн мэдээлэл, видео шторк хийж цахим хуудсанд байршуулж нийт 28195 хүнд хандсан байна.
8. Уншигч иргэд, хүүхэд багачуудад зориулан “Чамтай учрахаас өмнө”, “Үнэр”, “Дэгдээхэй жигүүр ургаж гүйцэхүй”, С.Дашдооров “Хөдөөгийн мөнгөн сар”, О.Дашбалбар “Талын хөх чоно” "Печень" ,"Буяны хишигтэй авдар" ,"Залхуу муур" ,"Хараацай хэдгэнэ хоёр", "Цэцэн бэрийн үлгэр", "Ухаант туулайн үлгэр" Монгол ардын үлгэр“ “Тавгийн идээ засах ёсон”, “Битүүлэх ёс”, “Хадагтай золгох ёс”, ”Цагаан сарын тухай” зэрэг монгол ёс заншил, танин мэдэхүй, өгүүллэг тууж, яруу найраг, үлгэр зэрэг цахим номыг Говьсүмбэр Нийтийн Номын сан, Говьсүмбэр Номын сан сайт дээр байршуулж, нэвтрүүлэхэд нийт 20579 уншигч хандалт хийсэн байна.



9. Боржигин өв соёл түүх, музейн үзмэрийг тайлбарыг цахимаар хуудсанд байршуулан 2500 хүн, музейн боловсрол олгох цахим сургалт мэдээллийг 6786 хүн үзсэн байна.

Тайланг нэгтгэсэн: БСУГ-ын бичиг хэрэг Ц.Баярмаа